

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2015 оны 02 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны ээлжит бус хурал товлосон ёсоор 2015 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 10:05 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-18 хаяганд байрлах Тахько (ХК) компанийн оффисын байранд эхлэв. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн хурлаас гаргасан шийдвэрийн дагуу энэхүү ээлжит бус хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Батболдын Батхуяг даргалав.

Б.Батхуяг: Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн өнөөдрийн ээлжит бус хуралд тус компанийн саналын эрх бүхий 1,189,983 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг 624 хувьцаа эзэмшигчид оролцохоос саналын эрхтэй 1,052,292 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирсэн нь нийт саналын эрхийн 88.4 хувь болж, хурлын ирц Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, Компанийн дүрмийн 7.1.16 дахь заалтын дагуу хурлын ирц хүчин төгөлдөр болсон тул Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 02 дугаар сарын 05-ны өдөр хуралдуулахаар товлосон ээлжит бус хурал нээснийг мэдэгдэе. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн хурлаас гаргасан шийдвэрийн дагуу өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахаар тогтоож, хурлаар хэлэлцэх асуудал болон санал авах хуудасны загварыг баталсан бөгөөд ээлжит бус хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссын даргаар Л.Буянбат, гишүүдээр С.Итгэл, Ж.Чимэдцэрэн, Ш.Мөнх-Очир нарыг, ээлжит бус хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Б.Батхуягийг, Тооллогын комиссын даргаар Д.Минжмаа, гишүүнээр Н.Гомбосүрэн, П.Сансартуяа нарыг томилсон болохыг мэдэгдэж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн хурлын 01 дүгээр тогтоолыг уншиж танилцуулав.

Ээлжит бус хурлаар хувьцаа эзэмшигч Ж.Чимэдцэрэнгийн ирүүлсэн санал, шаардлагын дагуу Тахько (ХК) компанийн нийт хувьцаанаас хувьцаа эзэмшигч асан Ц.Наст, Т.Доржготов, Ш.Мөнх-Очир нарын 272,775 ширхэг хувьцааг хасаж, Тахько (ХК) компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэнэ. Ээлжит бус хурлын үйл ажиллагааны дараалал, хурлын дотоод дэг, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулж, хурлын дотоод дэгийг батлав.

Ж.Чимэдцэрэн: Хурлын тэмдэглэл хэн хөтлөж байгаа вэ?

Б.Батхуяг: Хурлын тэмдэглэл хөтлөгч нь Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Ш.Мөнх-Очир хөтөлнө.

Ж.Чимэдцэрэн: Энэ дээр нэг санал тавьмаар байна. Хурлаар хэлэлцэж байгаа асуудалд Ш.Мөнх-Очир нь Татекс (ХХ) компанид хувьцаа эзэмшигч байсан бөгөөд түүнтэй холбогдох асуудлыг хэлэлцэж байгаа тул сонирхолын зөрчилтэй гэж үзэж хурлын тэмдэглэл хөтлөгч хүнээр өөр хүнийг сонгох саналтай байна.

Б.Батхуяг: Таны саналыг хүлээж авлаа. Ш.Мөнх-Очир гуайн нэр дээр бүртгэлтэй хувьцаатай холбоотой асуудал яригдаж байгаа тул сонирхолын зөрчилтэй гэж үзэж байгаа юм байна. Танд санал болгож байгаа хүн байна уу.

Ж.Чимэдцэрэн: Хуучин ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хийж байсан Ц.Доржготов эсвэл тус компанийн ажилтан Э.Чулуунтогтох нарын аль нэгийг сонгох саналтай байна.

Б.Батхуяг: Хурлын тэмдэглэл хөтлөгч хүнийг өөрчлөх энэ саналыг хуралд оролцож байгаа бусад хувьцаа эзэмшигчид зөвшөөрч хурлын тэмдэглэл хөтлөгчөөр Тахько (ХК) компанийн менежер, хувьцаа эзэмшигч Э.Чулуунтогтохыг хуралд оролцогчдын 100 хувийн саналаар томилов.



Б.Батхуяг: Хурлын дотоод дэгийн дагуу хурлаар хэлэлцэх асуудалдаа ороё. Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүн Ж.Чимэдцэрэн танилцуулж мэдээлэл хийнэ.

Ж.Чимэдцэрэн: Би товчхон ярья гэж бодож байна. Яагаад гэхээр хувьцаа эзэмшигчдэд тараасан материал дотор миний тавьсан шаардлага болон холбогдох мэдээлэл бүрэн эхээрээ очсон байгаа. Би өөрийгөө танилцуулаад мэдээллээ эхлэе. Миний бие Тахько (ХК) компанийн 369,824 ширхэг хувьцааг эзэмшигч буюу 31,08 хувийг эзэмшигч бөгөөд энэ компанийг анх үүсгэн байгуулагч бөгөөд 30 гаруй жил ажилласан хүний хувьд бүх үйл ажиллагаа өнгөрсөн процессыг сайн мэднэ. Өнөөдрийн бидний хэлэлцэж шийдэх гээд байгаа 272,775 ширхэг хувьцаа нь компанийн нийт хувьцааны 22,92 хувийн саналын эрхтэй хувьцаа байгаа гэдгийг мэдээлэх нь зүйтэй гэж үзэж байна. Энэ асуудал нь нилээн эртнээс яригдаж байсан, процедур нь явагдаад өнгөрсөн асуудал бөгөөд энэ асуудлыг нөхөж хэлэлцэж шийдвэрлэхээр оруулж байгаа учраас эдгээр зүйлийг ярихын өмнө түүх сөхөх зүйтэй гэж үзэж байна. Энэ асуудлыг компанид болон Санхүүгийн зохицуулах хороонд нилээн олон удаа хандаж хууль бус шийдвэр гарсан энэ асуудлыг шийдээчээ гэж шаардлага тавьж байсан. Намайг энэ компанид ажиллаж байхад Санхүүгийн зохицуулах хорооноос шалгалт хийж байсан бөгөөд энэ асуудлаа шийдээчээ гэж би ТУЗ-д хандаж байсан. 2009 онд би ТУЗ-ийн хурлаар энэ асуудлыг шийдье гэж иж бүрэн материал оруулж байсан ч тухайн үед ТУЗ нь хэлэлцээгүй. 2010 онд би ажлаасаа халагдаад энэ асуудал нь орхигдсон бөгөөд энэ асуудлын талаар мэргэжлийн байгууллагуудаар хөөцөлдсөн байгаа. Хамгийн сүүлд 2014 онд Санхүүгийн зохицуулах хороо ээлжит бус шалгалт хийе гэсэн шийдвэр гаргаад 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гаргаж Тахько (ХК) компани дээр шалгалт хийгээд 2014 оны 06 дугаар сарын 08-нд тайлан гаргасан бөгөөд ТУЗ-ийн дарга Л.Буянбат, Гүйцэтгэх захирал Л.Энхнасан нар танилцсан байгаа. Энэхүү дүгнэлтийн нэг хувийг би өөрөө авсан мөн компанид ч хувийг өгсөн байдаг. Энэ тайлангийн хувийг хувьцаа эзэмшигчид авч танилцаж болно. Энэхүү 272,775 ширхэг хувьцааны асуудал нь яагаад сөхөгдөөд байдаг вэ гэвэл Тахько (ХК) компани 1992 онд хувьцаат компани болон өөрчлөн байгууллагадсан байгаа. 1996 онд 687,680 ширхэг хувьцаа нэмж гаргасан бөгөөд нийт хувьцааны тоог дээр хэлчихсэн учир дахиж хэлэх шаардлагагүй байх гэж бодож байна. Хувьцаа нэмж гарсаны дараа Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 1995 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 02 тоот тогтоолор Тахько (ХК) компани, Тайваны "Грэйт Айвэн Ко. Лтд" компанитай хамтран оёдлын үйлдвэрүүдийг байгуулахаар шийдвэрлэн хоёр талын хамтарсан 50:50 хувийн хөрөнгө оруулалттай "Айтекс", "Татекс" компаниудыг 1995 онд байгуулсан. Тахько (ХК) компани эдгээр хоёр хамтарсан компанид өөрийн үл хөдлөх хөрөнгө, барилга байшингаар хөрөнгө оруулалтаа хийж, гадаадын компани нь тоног төхөөрөмж болон бусад эргэлтийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийж үйл ажиллагаагаа явуулсан байдаг. Улмаар хоёр хамтарсан компани үйл ажиллагаагаа явуулж байх хугацаанд 2004 оноос гадаад зах зээлийн байдлаас болж тус компаниудын үйл ажиллагаа нь доголдож эхэлсэн тул хөрөнгө оруулагч талууд харилцан тохиролцож Тахько (ХК) компани нь "Татекс" (ХХ) компанийг, Тайваны "Грэйт Айвэн Ко. Лтд" компани нь "Айтекс" (ХХ) компанийг тус тус 100/100 хувь эзэмшиж үйл ажиллагааг нь хариуцан авсан байдаг. Ингээд 2004 оноос хойш Татекс (ХХ) компани нь Тахько (ХК) компанийн 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компанийн хэлбэрээр цаашид үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. Санхүүгийн зохицуулах хорооноос томилогдсон ажлын хэсэг өөрийнхөө дүгнэлтэнд бол хэдэн хэдэн чиглэлээр шалгалт хийж ерөнхий танилцуулгыг гаргаж хувьцаа эзэмшигчдийн судалгааг гаргасан байдаг. Мөн дүгнэлтэнд нэгдүгээрт, ямар эрх бүхий этгээдийн шийдвэрээр Тахько (ХК) компаниас Татекс (ХХ) компани тусгаарласан болохыг тогтоосон байна. Хоёрдугаарт, дээрх эрх бүхий этгээд нь Компанийн хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх талаар дүгнэлтээ гаргасан байгаа. Энэ дүгнэлтэд 2004 онд энэ компани нь охин компани болохыг тогтоосон бөгөөд Тахько (ХК) компанийн охин компани болжээ гэдгийг шийдвэрлэсэн байгаа. Гэхдээ 2000 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр энэ компанийг тусгаарлах 07 тоот тогтоолыг гаргажээ гэж энэ дүгнэлтэнд оруулжээ. Иймд нэгэнт хамтарсан компани байгуулагдсаны дараа компани тусгаарлах тухай шийдвэр дахин гаргасан нь хуулийн нэр томъёог буруу ашигласан, 3 хувьцаа эзэмшигчдэд эзэмшиж буй хувьцаанд нь оногдох хөрөнгийг хувьцаат компанийн хөрөнгөөс салган эзэмшүүлсэн үйлдэл болсон байна гэж үзжээ. Хууль зүйд нийцэж байгаа эсэхийг Санхүүгийн зохицуулах хороо ийм байдлаар тогтоожээ. Энэ явцад Тахько (ХК) компанийн хувьцааны бүртгэлд 4 удаа өөрчлөлт орсон байдаг бөгөөд 2 удаа нэмэгдсэн 2 удаа хасагдсан байдаг. Хоёр удаагийн нэмэгдсэн

хувьцаануудыг хувьцаа эзэмшигч Р.Лутаагийн нэр дээр бүртгэгдсэн болохыг энэхүү дүгнэлтэд тусгагдсан байна. Мөн ямар хэмжээний хөрөнгийг уг 3 хувьцаа эзэмшигчид өгсөн бэ, тайлан балансдаа яаж тусгасан бэ гэхээр офис, үйлдвэрийн талбай болох 1343,1 м2 талбай, дээрээс нь 1 давхарын 400 м2 талбай, нийт 1743,1 м2 талбайг 3 хувьцаа эзэмшигчид шилжүүлж өгчээ гэж тогтоосон байгаа. Энэхүү шилжүүлсэн хөрөнгийн хэмжээг уг дүгнэлтэд дэлгэрэнгүй тусгасан байна.

Мөн Тахько (ХК) компаниас Үнэт цаасны хорооны бүртгэл санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст Компани тусгаарласан тухай мэдэгдэлийг 2000 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлсэн байдаг. Тус мэдэгдэлд Тахько (ХК) компани нь Иргэний хуулийн 38 дугаар зүйлийн 5, 169 дүгээр зүйлийг үндэслэн компанийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр тусгаарлан ажиллуулахаар иргэн Ц.Наст, Т.Доржготов, Ш.Мөнх-Очир болон иргэн Д.Энхтуяа, Ц.Баярмаа нартай хэлэлцээр байгуулж, энэ үндсэн дээр компанийг тусгаарлах тухай шийдвэрийг Компанийн тухай хуулийн 22 дугаар зүйлийг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөл гаргасан байна гэжээ. Уг мэдэгдэлийн хариуд Үнэт цаасны хорооноос Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд хандан 2000 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 130 тоот албан бичгийг хүргүүлсэн байна. Тухайн үед Үнэт цаасны хороо Компанийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу тусгаарлах замаар байгуулагдах компанийн нийт хувьцааг Тахько (ХК) компани өөрөө эзэмших ёстой гэсэн дүгнэлттэй, байр суурьтай байсан байна. Тухайн үед энэ албан бичиг ирж байсан. Ингээд нийт 272,775 ширхэг хувьцаанд оногдохоор тооцож барилга, тоног төхөөрөмж, эд хогшлыг Татекс (ХХ) компанид, 471,598 ширхэг хувьцаанд оногдохоор бодож барилга байгууламжийг шинээр байгуулагдах "Марс Төв" (ХХ) компанид тус тус шилжүүлэхээр шийдвэрлэсэн нь компанийн хөрөнгийг хөндлөнгийн этгээдэд тусгаарлан эзэмшүүлэх хууль бус шийдвэр болсон тул ТУЗ-ийн энэ шийдвэрийн дагуу тусгаарлах үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байж энэхүү асуудлаа хуульд нийцүүлэн шийдвэрлэх нь зүйтэй гэж мэдэгдэж байжээ. Асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх тухай мэдэгдэлийг мэргэжлийн байгууллагаас ирүүлж байжээ. Тайлангийн эхний хэсэгт дурдсанчлан нийт 4 удаа Тахько (ХК) компанийн гаргасан хувьцааны тоонд өөрчлөлт орж байсан бөгөөд Татекс (ХХК) компанитай холбоотой ямар нэгэн өөрчлөлт одоог хүртэл орж байгаагүй байна гэж дүгнэсэн байгаа.

Компанийг тусгаарласан нь компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжинд нийцсэн эсэх гэсэн бүлэг дүгнэлт байна. Энэ дээр болохоор 2000 оны 03 дугаар сард гэрээ хийх үеийн байдлаар Тахько (ХК) компанийн үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлээс харахад Ц.Наст 400 ширхэг хувьцаатай, Ш.Мөнх-Очир 11519 ширхэг хувьцаатай, Т.Доржготов нь 85 ширхэг хувьцаатай тус тус эзэмшиж байжээ гэсэн байна. Тэгэхээр одоо бид нарын хасах тухай хэлэлцэж байгаа хувьцаа нь эдгээр хүмүүсийн нэр дээр тухайн үед байгаагүй байсан бөгөөд эдгээр хувьцаа нь иргэн Р.Лутаагийн нэр дээр бүртгэлтэй байсан тул өөрсдийнх нь нэр дээр тухайн үед шилжээгүй юмуу эсвэл албан ёсоор хувьцаа эзэмшигч гэж тогтоогдоогүй байсан байна. Харин тухайн үед гэрээгээр 687,680 ширхэг хувьцааг нэр бүхий 7 хүн дараа нь 2 хүн нэмэгдээд хувааж эзэмшиж байжээ гэж дэлгэрэнгүй байдлаар энэ дүгнэлтэнд заагаад өгчихсөн байна. Энийг талаар дэлгэрэнгүй мэдэх шаардлагатай гэвэл харж болно. Энийг дэлгэрэнгүй ярихаар цаг их авах гээд байх шиг байна.

Харин Татекс (ХХ) компанийн 2008 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нийт 257,300,000 төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, Түдэвийн Доржготов гэсэн нэг хувьцаа эзэмшигчтэй гэж тусгасан байна. Тэгэхээр уг тусгаарласан компани нь 1 хувьцаа эзэмшигчтэй, дээр дурдсан компани болохыг бүртгэсэн байна.

Иймд Тахько (ХК) компаниас Татекс (ХХ) компанийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулсан гэж үзэхээргүй байгаа бөгөөд харин нэгэнт байгуулагдсан хараат компани болох Татекс (ХХ) компанийн хувьцааг бусдад шилжүүлсэн үйлдэл гэж үзсэн болохыг дүгнэлтэд тусгажээ. Ажлын хэсгийн дүгнэлтийн гол агуулга нь сая ярьсан зүйлүүдийг дурдаад ийм ийм зүйлүүдийг шийдвэрлэсэн байна гэж үзээд Тахько (ХК) компанид үүрэг өгсөн байна. Тахько (ХК) компани нь 1996, 2004 онуудад 2 удаа нэмж үнэт цаас гаргасан байдаг бөгөөд нэмж гаргасан хувьцааны өмчлөх эрхийн бүртгэл иргэн Р.Лутаагийн нэр дээр үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгэгдэж байсан байна. Гэхдээ нэр бүхий 7 иргэний хооронд хувьцаа эзэмших тухай гэрээ хэд хэдэн удаа байгуулж байжсан бөгөөд эдгээр 7 иргэнээс Ж.Чимэдцэрэн 2012 онд өөрийн өмчлөлд хувьцаагаа шилжүүлэхээр шүүхэд хандан нэхэмжлэл гаргаж байсан бөгөөд шүүх хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны дүнд нэхэмжлэлийг үндэслэлтэй гэж үзэн шийдвэрлэсэн. Энэхүү шийдвэрийг үндэслээд харахад

Ц.Наст, Т.Доржготов, Ш.Мөнх-Очир нар нь Тахько (ХК) компанийн нийт 272,775 ширхэг хувьцаа эзэмшигч байх боломжтой юм. Иймд хувьцаат компанийн аж ахуйн үйл ажиллагааны үр дүнд тухайн компанийн хөрөнгийн хэмжээ ялангуяа, үндсэн хөрөнгийн хэмжээ багассан гэж үзэхээргүй байх тул компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчиддээ тэдгээрийн эзэмшиж буй хувьцаанд оногдох хөрөнгийг шилжүүлсэн үйл ажиллагаа гэж үзлээ. Шалгалтын ажлын хэсгийн зүгээс дээрх дүгнэлттэй холбогдуулан Монгол улсын үнэт цаасны зах зээлд худалдахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд Тахько (ХК) компанийн гаргасан хувьцааны тоо хэмжээтэй холбоотой өөрчлөлт оруулах талаар Хороонд асуудал тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэн 2014 оны 08 дугаар сарын 04-ний өдөр Тахько (ХК) компанийн Гүйцэтгэх захиралд 2 удаа албан шаардлага хүргүүлсэн байдаг. Уг шаардлагад компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж хурлаараа 272,775 ширхэг хувьцааны талаархи асуудлыг хэлэлцэж үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах замаар энэ асуудлыг шийдвэрлэж хасалтаа хий гэсэн албан шаардлагыг хүргүүлсэн байдаг. Надад 2014 оны 12 сарын 22-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос бичиг ирүүлж таны ирүүлсэн өргөдөлтэй холбогдуулж компанид чинь энэ асуудлаар хандсан боловч компанийн зүгээс шаардлага биелүүлэхгүй байгаа тул та өөрийн шаардлагаа тавиагчээ гэсний дагуу би 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдөр шаардлагаа компанид тавьсан байгаа. Энэ шаардлагыг та бүхэнд тараасан бөгөөд энэхүү 272,775 ширхэг хувьцаа нь хий байдлаар компани бүртгэл дээр яваад байгаа нь хуульд нийцэхгүй байна гэсэн мэргэжлийн байгууллагын дүгнэлт нэгэнт гарсан тул та бүхнийг энэ асуудалд нухацтай хандаж компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулж цаашдаа хувьцаат компанийн үйл ажиллагаа, олон хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хөндөгдөж байгаа учраас үүнийг залруулж оруулах нь зүйтэй гэсэн үүднээс уг асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж ийм мэдээлэлийг хүргэж байна. Шаардлагатай гэж үзвэл холбогдох материалыг надаас эсвэл компаниас авч болно. Дэлгэрэнгүй зүйлийг асуулж болно би асуултанд хариулахад бэлэн байна.

Б.Батхуяг: Хурлын дэгийн дагуу хувьцаа эзэмшигчдэд асуулт байвал асуултаа тавья.

Л.Буянбат: Би хувьцаа эзэмшигч Ж.Чимэдцэрэнгээс нэг асуулт асууя. Тэр нэр бүхий холбогдож байгаа Ц.Наст агсан, Ш.Мөнх-Очир, Т.Доржготов гэсэн 3 хүнтэй холбоотой ТУЗ-ийн тогтоол 2000 онд гарсан гэж байгаа. Энэхүү компани тусгаарлах тогтоол гарсаны дараагаар Санхүүгийн зохицуулах хорооноос энэ асуудлаа хуульд нийцүүлж шийдвэрлэж гэсэн тогтоол гарсан гэж хэллээ. Тэр тогтоол нь 2000 онд гарсан юмуу?

Ж.Чимэдцэрэн: Санхүүгийн зохицуулах хорооноос 2000 оны 12 сарын 14-ны өдөр 130 тоот албан бичиг ирүүлсэн.

С.Дамдиндоо: Сая танилцуулсан материалаас үзэж болох уу?

Б.Батхуяг: Танилцуулсан материалыг хувьцаа эзэмшигчдэд хувилаад тараачих.

Л.Буянбат: Тусгаарлах тогтоол уу?

Ж.Чимэдцэрэн: 2000 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн тогтоол байна.

Л.Буянбат: Тэр тусгаарлах тогтоол нь энэ яригдаж байгаа 272,775 ширхэг хувьцааны асуудалтай ямар холбоотой юм.

Ж.Чимэдцэрэн: Тэгэхээр Т.Доржготов, Ц.Наст, Ш.Мөнх-Очир нарын 272,775 ширхэг хувьцаа эзэмшигчид нь Татекс (ХХ) компанийг тусгаарлаж ажиллуулах тухай хүсэлт Тахько (ХК) компанид гаргаад түүний дагуу Тахько (ХК) компанийн охин компани болох Татекс (ХХ) компанийг тусгаалах тухай гэрээг 2000 онд байгуулсан. Уг гэрээг үндэслээд Татекс (ХХ) компанийг тусгаарлаж ажиллуулах тухай Тахько (ХК) компанийн ТУЗ-ийн тогтоол гарсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хороонд тусгаарлаж ажиллах гэж байна гэсэн мэдэгдэл гаргасан боловч энэ асуудал чинь хуульд нийцэхгүй байна, хуульд нийцүүлэн шийдвэрлэх тухай хариу ирсэн байдаг. Түүнээс хойш энэ асуудлыг шийдээгүй зогссон. Гэхдээ энэ асуудал нь 2 компанийн нэр дээр, тухайлбал Марс төв (ХХ) болон Татекс (ХХ) компаниуд дээр ирсэн байдаг бөгөөд Марс төв (ХХ) компанийг эчнээ санал хураалтаар 470 мянган ширхэг хувьцаа хасуулаад шийдсэн байдаг. Харин Татекс (ХХ) компанийн 3 хувьцаа эзэмшигч хөрөнгөө авсан мөртлөө хувьцаагаа хасуулаагүй явчихсан нь зөрчилтэй болчихсон.

Л.Буянбат: 1995 онд хамтарсан компани 10 жилийн хугацаатай байгуулсан гэсэн тэгээд 2005 он хүртэл хамтарсан компани гэдгээрээ явах юм биш үү, тэр чинь охин компани биш шүү дээ. Хоёр талын 50:50 хувийн хөрөнгө оруулалттай байгуулсан гэсэн биз дээ. Тэгэхээр тэр 2 компани чинь хамтарсан компани шүү дээ. Нөгөө талаас аливаа компанийн 50-иас дээш хувийг эзэмшиж байж охин компани гэж үзнэ шүү дээ.

Ж.Чимэдцэрэн: Би өмнө нь хэлсэний дагуу үйл ажиллагааны хувьд доголдож эхэлсэн

тул хөрөнгө оруулагч компаниуд тохиролцож тус 2 компанийг салгаж Тахько (ХК) компани нь "Татекс" (ХХ) компанийг 100 хувь эзэмшиж, Тайваны "Грэйт Айвэн Ко. Лтд" компани нь "Айтекс" (ХХ) компанийн 100 хувь эзэмшиж, ашиг алдагдлаа талууд өөрсдөө хариуцан үйл ажиллагааг нь тус тусдаа хариуцан авсан байдаг. Тэгэхээр тэр чинь Тахько (ХК) компанийн 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани болно биз дээ.

Л.Буянбат: Гадаадын хөрөнгө оруулагчтайгаа ярилцаж тохиролцоод 2004 онд компаниудын үйл ажиллагааг салгасан гэж байна Та хэлсэн. Тэгэхээр энэ нь 2000 оны тусгаарласан ТУЗ-ийн тогтоол ямар холбоотой юм хамаагүй юм биш үү.

Ж.Чимэдцэрэн: Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан дүгнэлтийг л би танилцуулж байна. Энэ 3 хувьцаа эзэмшигч 2000 онд "Татекс" (ХХ) компанийг хариуцаад ажиллаж байх хугацаандаа Тахько (ХК) компанийн 100 хувь компани болгое гээд 2004 онд шийдвэрлэсэн. Санхүүгийн зохицуулах хорооны энэхүү дүгнэлт нь Тахько (ХК) компани дээр байгаа байх. Шаардлагатай гэж үзэж байгаа бол Санхүүгийн зохицуулах хороон дээр ч байж байгаа байх.

Л.Буянбат: Тэр нэр бүхий хүмүүс нь өөрсдөө хувьцаагаа хасуулъя гэсэн хүсэлтээ гаргаж байсан юм уу?

Ж.Чимэдцэрэн: Би яаж мэдэх юм. Тэд хөрөнгөө эзэмшээд байгаа юм чинь гаргах ёстой ш дээ. Яагаад гаргадаггүй юм. Та нарт гаргах ёстой ш дээ. Санхүүгийн зохицуулах хорооноос 2000 онд 130 тоод албан бичиг ирсний дагуу Тахько (ХК) компаниас харин энэ асуудлыг хуульд нийцүүл гэсэн албан тоотыг Татекс (ХХ) компанид өгч байсан.

Л.Энхнасан: Та тэр үед Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан шүү дээ.

Г.Оюунгэрэл: Тэр хүмүүс чинь хөрөнгөө аваад гарчихаараа хувьцаа эзэмшигч биш болчихож байгаа юм биш үү.

Ж.Чимэдцэрэн: Өөрсдийн эзэмшиж байгаа хувьцаагаа өөр хүний нэр дээр байршуулчихаад тэрийг одоо өөрсдөө хасуулах хүсэлтээ тэр хүмүүс гаргах ёстой ш дээ. Яагаад гаргадаггүйг би мэдэхгүй ш дээ.

Л.Буянбат: Энэ асуудал нь тэр хүмүүстэй холбоотой юм бол та энд ямар холбоотой байх вэ?

Ж.Чимэдцэрэн: Миний эрх ашиг хохирч байна.

Г.Оюунгэрэл: Хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хохирч байна.

Ж.Чимэдцэрэн: 22.92 хувийн саналын эрхтэй 272,775 хувьцааг хэн нэгэн эзэмшээд байна ш дээ. Энэ хувьцаа нь хасагдсанаар энэ хэмжээний саналын эрх буурч бусад хувьцаа эзэмшигчдийн саналын эрх нэмэгдэх ёстой. Нөгөө талаас, энэ хувьцаанд ногдол ашиг хувиарлагдаад байгаа энийг бас нэг хүн аваад байна. Энэ ноогдол ашгийг аваад байгаа хэн нэгэн хүн нь бусад хувьцаа эзэмшигчдээс оногдох ёстой ногдол ашгийг аваад байгаа.

Л.Буянбат: Тэр хүн нь хэн юм бэ.

Ж.Чимэдцэрэн: Жишээлбэл та тэр ногдол ашгийг аваад байна.

Л.Буянбат: Тэр 272,775 ширхэг хувьцааний хэдэн ширхэг нь миний нэр дээр байгаа юм бэ.

Ж.Чимэдцэрэн: Энэ талаар би шаардлагадаа тодорхой заасан байгаа. Жишээлбэл, Ш.Мөнх-Очирын нэр дээр 272,775 ширхэг хувьцааны 11,519 ширхэг хувьцаа нь бүртгэлтэй байж байна. Дүгнэлт дээр бичсэн байгаагаар 1998 онд 687,680 ширхэг хувьцааг нэр бүхий 7 хүн хувааж эзэмшихээр гэрээ хийсэн байдаг. Тэр нэр бүхий хүмүүс дотор нь Р.Лутаагийн 130,658 ширхэг хувьцаа, Ч.Батбилэг, Ц.Наст, Т.Доржготов, Ж.Чимэдцэрэн, Л.Эрдэнэбат, Ш.Мөнх-Очир нарын бүгдийнх нь нэр дээр 92,837 ширхэг хувьцаагаар хувааж авсан байдаг. Түүний дараа 2000 онд өөрчлөлт ороод нэр бүхий 7 хүн Р.Лутаа 124,680 ширхэг хувьцаа, Ч.Батбилэг, Ц.Наст, Т.Доржготов, Ж.Чимэдцэрэн, Л.Эрдэнэбат, Ш.Мөнх-Очир нар нь тус бүр 80,000 ширхэг хувьцааг эзэмшихээр болсон байдаг. Энэ Ц.Наст, Т.Доржготов, Ш.Мөнх-Очир нарын тус бүр 80,000 ширхэг хувьцаа нь Р.Лутаагийн нэр дээр бүртгэлтэй байдаг тул одоо хууль ёсны өв залгамжлагч Л.Буянбат таны нэр дээр ирсэн байгаа.

Л.Буянбат: Ш.Мөнх-Очир гуайн нэр дээр байсан 80,000 ширхэг хувьцаа бүгд одоо миний нэр дээр байгаа гэж үзэж байна уу?

Ж.Чимэдцэрэн: Тийм. Тэгж үзэж байна. За тэгээд нэг 49,000 ширхэг хувьцаа гаргаад энэ 7 гишүүн хувааж эзэмшихээр заагдсан байдаг. Тэр хувьцаа нь бол 14,174 ширхэг хувьцаа нь Тахько (ХК) компанийн нэр дээр бүртгэлтэй байх гэж бодож байдаг Ш.Мөнх-Очир нь өөрийн эзэмшлийн 80,000 ширхэг хувьцаан дээрээ 7000 ширхэг хувьцааг нэмээд 87,000 ширхэг хувьцаагаа зарчихсан гээд байдаг шүүхээр явж байхад энэ асуудал яригдаж байсан.

Л.Буянбат: Би нэг юм тодруулаад хэлье. Та шүүхээр яваад 314,114 ш хувьцааг миний

нэр дээрээс хасуулаад авсан. Тэр хувьцаан дотор Мөнх-Очир гуайн хувьцаа явж байгаа юу.
Ж.Чимэдцэрэн. Тэгсэн. Явж байгаа.

Л.Буянбат: Та тэгээд өөрт ногдох хувьцаагаа авсан биз дээ. Тэр нь хэдэн ширхэг хувьцаа юм бэ.

Ж.Чимэдцэрэн: Өөрт ногдох хувьцаагаа авсан. Тэр нь 49,700 орчим ширхэг хувьцаа байгаа. Шүүхийн шийдвэрээр авсан байгаа.

Алтансүх: Та одоо компанийн захирлаар ажиллаж байгаа юм уу.

Ж.Чимэдцэрэн: Би одоогоор компанид ажиллахгүй байгаа. 2010 онд ажлаасаа үндэслэлгүй халагдсан. Шүүхийн шийдвэрээр буцаад томилогдоод байгаа.

Ш.Мөнх-Очир: Би тус компанийн хувьцаа эзэмшигч бөгөөд Тахько (ХК) компанийг үүсгэн байгуулагчдын нэг гишүүн юм. Өнөөдрийн хурлаар хувьцаа эзэмшигч Ж.Чимэдцэрэнгийн санал, шаардлагын дагуу Тахько (ХК) компанийн нийт хувьцаанаас хувьцаа эзэмшигч асан Ц.Наст, Т.Доржготов, Ш.Мөнх-Очир нарын 272,775 ширхэг хувьцааг хасаж, Тахько (ХК) компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, улмаар миний нэр дээр байгаа 11,519 ширхэг хувьцааг хасуулах тухай асуудал хэлэлцэж байна. Хувьцаа эзэмшигч Ж.Чимэдцэрэн хэлэлцэж буй асуудлаар дэлгэрэнгүй мэдээлэл хийлээ. Энэ асуудлаар би өөрийн зүгээс холбогдох тайлбарыг хийж байна.

Тэгэхээр 1995 онд Тахько (ХК) компани, Тайваны "Грэйт Айвэн Ко. Лтд" компанитай хамтран оёдлын үйлдвэрүүдийг байгуулахаар шийдвэрлэн хоёр талын хамтарсан хөрөнгө оруулалттай "Айтекс", "Татекс" (ХХ) компаниудыг 50:50 хувийн хөрөнгө оруулалтаар 10 жилийн хугацаатайгаар байгуулж, Тахько (ХК) компанийн 1996 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дээрхи шийдвэрийг баталсан юм. Тэр үед миний бие 1995-2000 онуудад тус хоёр хамтарсан компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан. Хамтарсан компани дээр хоёр талаасаа 2:2 хүний бүрэлдэхүүнтэй ТУЗ ажиллаж байсан. Хамтарсан компаниуд 1995-2000 оны хугацаанд амжилттай үйл ажиллагаа явуулж байсан боловч 2000 оноос гадаад, дотоодын нөхцөл байдал, зах зээлийн байдлаас хамтарсан хоёр компанийн үйл ажиллагаа доголдож, алдагдалтай ажиллах болсон тул хөрөнгө оруулагч талуудын шийдвэрээр 2000 оноос Тахько (ХК) компани нь хамтарсан хөрөнгө оруулалттай "Татекс" (ХХ) компанийн, Тайваны "Грэйт Айвэн Ко. Лтд" компани "Айтекс" (ХХ) компанийн үйл ажиллагааг тус тусдаа өөрсдөө ашиг, алдагдлаа хариуцаад бие даан хариуцан ажиллаж эдгээр 2 компани нь 2006 онд үйл ажиллагаагаа зогсоосон юм. Энэ хугацаанд Тахько (ХК) компанийн нэр бүхий 3 хувьцаа эзэмшигч нь 2000 оны 04 дүгээр сарын 12-ны хэлэлцээрээр Тахько (ХК) компанийн эзэмшлийн хамтарсан хөрөнгө оруулалттай "Татекс" компанийн үйл ажиллагааг хариуцан түүний зарим эрх, үүрэг, хариуцлагыг шилжүүлэн компани тусгаарлах хэлбэрээр ажиллахаар Тахько (ХК) компанитай гэрээ байгуулан ТУЗ-ийн шийдвэрийн дагуу ажилласан. Мөн 2000 онд Марс Төв (ХХ) компани тусгаарлах хэлбэрээр ажиллах шийдвэрээ гаргаж Тахько (ХК) компанийн нэр бүхий 3 хувьцаа эзэмшигч хамтарсан хөрөнгө оруулалттай "Татекс" (ХХ) компани, мөн нэр бүхий хувьцаа эзэмшигчид Марс Төв (ХХ) компани тусгаарлах хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулахаар гэрээ байгуулж ТУЗ-ийн шийдвэрийг гаргуулсан байдаг. Энэхүү шийдвэрийг гарснаас хойш ҮЦХ-ноос Тахько (ХК) компанид дээрх хоёр компанийг тусгаарлах шийдвэр хуульд нийцээгүй байна, компани тусгаарлах асуудлыг хуульд нийцүүлэн шийдвэрлэх талаар албан бичиг ирүүлсэн. Марс Төв (ХХ) компанийн хувьд нэр бүхий хувьцаа эзэмшигчид Тахько (ХК) компанитай харилцан тохиролцсоны үндсэн дээр 2002 онд хувьцаа эзэмшигчдийн эчнээ санал хураалтаар компанийг хувааж асуудлаа шийдвэрлэсэн байдаг. "Татекс" (ХХ) компанийн хувьд ямарваа нэгэн хуульд нийцсэн шийдвэр гараагүй бөгөөд Компанийн тухай хуулийн дагуу аливаа компанийн хуваах, нийлэх, нэгдэх, тусгаарлах үйл ажиллагаа нь зөвхөн хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд хамаарах асуудал тул энэ асуудал шийдэгдээгүй. Нөгөө талаас, "Татекс" (ХХ) компани нь бие даасан хамтарсан хөрөнгө оруулалттай компанийн хувьд уг асуудлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй байсан бөгөөд нэр бүхий 3 хувьцаа эзэмшигч болон Тахько (ХК) компанийн аль нэг талаас санаачилга гаргаагүй улмаас асуудал нь өдий хүртэл явчихсан байна. Үүний зэрэгцээ хувьцаа эзэмшигч Ж.Чимэдцэрэн нь 2000-2010 онуудад компанийн Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн байсан бөгөөд энэ асуудлыг шийдвэрлэх бүрэн боломжтой байсан. Бидний зүгээс энэ асуудлыг шийдвэрлэхэд ямарваа нэгэн хүндрүүлсэн асуудал гаргаагүй "Татекс" (ХХ) компанийг тусгаарласан компанийн хэлбэрээр үйл ажиллагаа хэвийн явуулж байсан.

Үүний зэрэгцээ би 2002 онд Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигч Р.Лутгаа агсантай хувьцаа худалдан авах, худалдах тухай гэрээг байгуулан өөрийн эзэмшлийн 98,606 ширхэг хувьцааг худалдсан. Өөрийн эзэмшлийн хувьцааг худалдсан учир "Татекс" (ХХ)

компанийн өмнө хүлээх үүрэг, хариуцлага дуусгавар болсон. Миний хувьд "Татекс" (ХХ) компанийг тусгаарласан хэлбэрээр ажиллуулж байсан нэр бүхий 3 хувьцаа эзэмшигчийн 272,775 ширхэг энгийн хувьцааг Тахько (ХК) компанийн хувьцаанаас хасаж, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах нь үндэслэлгүй гэж үзэж байна.

Мөн хэдий өөрийн эзэмшлийн хувьцааг худалдсан боловч хувьцаа эзэмшигч Р.Лутаа дарга агсан миний өөрийн нэр дээр байсан 11,519 ширхэг хувьцааг байршуулсан хэвээр байлгасан бөгөөд шилжүүлж авах талаар ямар нэгэн санал хүсэлт гаргаагүй. Улмаар Р.Лутаа дарга агсны өв залгамжлагч Л.Буянбат одоог хүртэл энэ 11,519 ширхэг хувьцааг шилжүүлж авах талаар ямарваа нэгэн санал хүртэл гаргаагүй байна. Миний нэр дээр байгаа 11,519 ширхэг хувьцааг шилжүүлэх эсэх асуудал хувьцаа эзэмшигч Л.Буянбат бид хоёрын хооронд шийдвэрлэх асуудал бөгөөд бид хоёрын дунд энэ талаар ямарваа нэгэн маргаантай асуудал байхгүй тул эдгээр 11,519 ширхэг хувьцааг хасуулах үндэслэлгүй гэж үзэж байна.

С.Дамдиндоо: "Татекс" (ХХ) компани хэдэн гишүүнтэй вэ. Хаана байрладаг юм бэ.

Ш.Мөнх-Очир: Тахько (ХК) компанийн өргөтгөлийн У-1 барилгад байршдаг. "Татекс" (ХХ) компанийн гишүүнээр Т.Доржготов, Ц.Наст агсны өв залгамжлагч Н.Энхнасан нарын 2 гишүүнтэй.

С.Дамдиндоо: 3 гишүүн тусгаарласан байсан нэг гишүүн нь хаачсан юм бэ.

Ш.Мөнх-Очир: Би 2002 онд хувьцаагаа худалдсанаас хойш "Татекс" (ХХ) компанийн үйл ажиллагаа, Тахько (ХК) компани болон хувьцаа эзэмшигчдийн хоорондын харилцааг мэдэхгүй байна. Энэ асуудлаар тус компанийн захирал Т.Доржготов тодорхой хариу тайлбар өгөх байх.

С.Дамдиндоо: Надад 2 асуулт байна. Нэгдүгээрт, Татекс (ХХ) компани нь Тахько (ХК) компанийн охин компани юм байна гэж ойлголоо. Санхүүгийн тайлангаа толгой компанидаа өгч байна уу. Хоёрдугаарт, Татекс (ХХ) компани болон Марс Төв (ХХ) компани хоёулаа 2002 онд тусгаарлах шийдвэр гаргуулсан байдаг. Татекс (ХХ) компани нь хувьцаа эзэмшигч асан Ц.Наст, Т.Доржготов, Ш.Мөнх-Очир нарын тус бүр 87,087 ширхэг хувьцаа, Марс Төв (ХХ) компани нь хувьцаа эзэмшигч Ч.Батбилэг, Л.Эрдэнэбат, Баярмаа, Энхтуяа нарын 474,000 ширхэг хувьцааг тусгаарласан байна. Тэгээд Тахько (ХК) компани нь 1,280,000 ширхэг хувьцаанаас Марс Төв (ХХ) компанид ногдох хувьцааг хасаад 880,000 орчим хувьцааг болсны дараагаар нэмж дахин хувьцаа гаргаж одоогийн 1,189,983 ширхэг хувьцаа бүртгэлтэй байгаа. Тэгэхээр "Татекс" (ХХ) компанийн хувьцаа хасагдаагүй байдаг. 2000 онд "Татекс" (ХХ) компани нь 3 гишүүнтэй, 272,775 хувьцаа эзэмшигч бүхий 3 гишүүнтэй байсан бол одоо 2008 онд 257,300,000 төгрөгийн хөрөнгөтэй, 1 гишүүнтэй компани гэж дурьдагдсан. Энэ олон зөрүүтэй тооны аль нь зөв тоо юм бэ.

Ш.Мөнх-Очир: 2000 онд дээр дурдсан 2 компанийг тусгаарласан шийдвэр гарсан. Тодорхой хугацааны явцад хувьцаа эзэмшигчид хоорондоо харилцан тохиролцож Марс Төв (ХХ) компанийг хуваах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн эцнээ санал хураалтаар шийдвэрлэж Тахько (ХК) компанийн нийт хувьцаанаас дээр дурдсан 474,000 ширхэг хувьцааг хассан байдаг. "Татекс" (ХХ) компанийн хувьд хэдий тусгаарлах шийдвэр гарсан боловч уг компани хамтарсан хөрөнгө оруулалттай компани байсан. Тайваны "Грэйт Айвэн Ко.Лтд." компани хэдийгээр "Айтекс" (ХХ) компанийг бие даан хариуцан ажиллаж байсан ч тус компани нь хамтарсан хөрөнгө оруулалттай компани байсан. Энэ хоёр хамтарсан компани 1995 оноос 2006 оныг хүртэл 10 жилийн хугацаатайгаар үйл ажиллагаагаа явуулж байсан компани юм. Би дээр дурдсан 2002 онд өөрийн хувьцаагаа Р.Лутаа дарга агсанд зарсан байсан тул түүнээс хойш, тэр тусмаа 2005 оноос хойш ямар хэлбэрээр, яаж явсан процессыг мэдэхгүй. Тэгэхээр 2005-2006 онд хамтарсан компаниуд татан буугдсанаас хойшхи хугацаанд "Татекс" (ХХ) компанийн үйл ажиллагааны талаар ямарваа нэгэн тайлбар хэлэх боломжгүй байна. Би дээр хэлсэн, Компанийн тухай хуулийн дагуу аливаа компанийн хуваах, нийлэх, нэгдэх, тусгаарлах үйл ажиллагаа нь зөвхөн хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд хамаарах асуудал.

Ж.Чимэдцэрэн: Би 2 асуулт асууя. Чи сая 11,519 ширхэг хувьцаагаа хасуулах нь үндэслэлгүй гэж ярих шиг боллоо. 11,519 ширхэг хувьцаандаа та ногдол ашиг авч байгаа юу. Хувьцаагаа зарчихсан хүн ногдол ашиг яагаад аваад аваад байгаа юм.

Ш.Мөнх-Очир: Тийм ээ. 11,519 ширхэг хувьцааг би эзэмшиж байгаа. Ногдол ашиг авч байгаа. Тэр ямар хамаатай юм. Р.Лутаа дарга агсан бид хоёр хоорондын тохиролцоогоор дээрх хувьцаа миний нэр дээр байршиж байгаа.

Л.Буянбат: Энэ нь таны асуудал биш шүү дээ. Танд ямар хамаатай юм бэ.

Ж.Чимэдцэрэн: Чи өмнө нь тэр хувьцааны 50 хувийг авсан биздээ гээд асуугаад

17/1/2008/384/ХС

байсан биз дээ.

Л.Буянбат: Тэгвэл яагаад шүүх тэр 11,519 ширхэг хувьцаанаас хасаагүй юм бэ?

Ж.Чимэдцэрэн: Шүүх тэр хувьцааг яагаад хасаагүй юм гэхээр нэгэнт та энэ гэрээнд оролцоогүй энэ хувьцааны эзэн Р.Лутаа гуайн өв залгамжлагч Л.Буянбат байгаа учраас танд энэ асуудал хамаа байхгүй та зөвхөн гаргуулах ёстой хувьцаагаа гаргуулахаас биш тэр хувьцааг зарсан авсан хоёр хүний хоорондын асуудал гээд энэ асуудал яригдах боломжгүй гээд хаачихсан. Тиймээс би Татекс (ХХ) компанийн үйл ажиллагаанд оролцох боломжгүй болсон. Тэр 11,519 ширхэг хувьцаагаа зарчихаад хасуулахгүй, ногдол ашгаа аваад байж байгаа нь их сонин санагдчихлаа.

Б.Батхуяг: Хувьцаа эзэмшигчдээ одоо зөвхөн санал оруулж байгаа асуудлын талаар ярилцана шүү.

С.Дамдиндоо: Би санхүүгийн тайлангаа толгой компанидаа өгдөг үү гэж асуусан.

Ш.Мөнх-Очир: Би одоо тэр компанийн гишүүн биш болохоор мэдэхгүй.

Ж.Чимэдцэрэн: Тэгвэл Н.Энхнасангаас асууя.

С.Дамдиндоо: Чи энэ компанийн гишүүн мөн үү.

Н.Энхнасан: Би энэ компанийн гишүүн биш.

С.Дамдиндоо: Тэгвэл яагаад 10 хэдэн жил нас барсан хүний нэр дээр энэ хувьцаа нь яваад байдаг юм.

Н.Энхнасан: Би энэ Тахько (ХК) компанийн хуралд өөрийн эзэмшлийн 401 ширхэг хувьцааны төлөөлөн оролцож байна.

Ж.Чимэдцэрэн: Та энэ компанид гишүүнээр элссэн юм уу.

Н.Энхнасан: Би энэ компанийг төлөөлөх эрх надад байхгүй тул энэ талаар би сайн мэдэхгүй.

Алтансүх: Татекс (ХХ) компаниас ашгаа авчихаад давхар Тахько (ХК) компаниас ашиг хүртэх нь байж болшгүй зүйл биз дээ.

Б.Батхуяг: Таны наад тавиад байгаа асуудлын талаар энэ үйл ажиллагаа явагдаж байх үед Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Ж.Чимэдцэрэн, одоо ажиллаж байгаа Гүйцэтгэх захирал Л.Энхнасан нараас асуух зөв гэж үзэж байна.

Ж.Чимэдцэрэн: Би эхлээд хариулчихъя. Анх компани тусгаарласан гэрээн дээр энэ 3 хувьцаа эзэмшигч нь ашиг орлого, алдагдлаа өөрсдөө хариуцна гэсэн байдаг. Санхүүгийн зохицуулах хярооноос энэ гэрээ чинь болохгүй байна гэсэн бичиг ирсэн байсан. Тэр үеийн үйл ажиллагааны явцыг ярья. Тэр үед шүүхийн асуудал тавигдсан байсан бөгөөд тэр хувьцаа нь битүүмжлэгдсэн учраас хасах боломжгүй байсан. Р.Лутаа гуай энэ хувьцаа нь хууль бус зүйл яваад байгаа одоо шууд хасаж болохгүй байна гээд ярьдаг байсан юм. Н.Аюуш гэдэг хүн ирээд өмнө ч ирж байсан ийм зөрчил одоо хүртэл яваад байна, энэ асуудлаа шийдээ гэдэг үүрэг өгч байсан. Би 2009 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр ТУЗ-д иж бүрэн материал оруулж байсан юм. Тус материал нь одоог хүртэл надад байж байна. Тухайн үед ТУЗ нь хэлэлцээгүй энэ асуудлыг орхигдуулсан.

Л.Буянбат: Би тайлбар хэлье. Тухайн үед Ж.Чимэдцэрэнгийн оруулж ирж байсан асуудал нь компанийн хэлбэрийг өөрчлөх тухай асуудал байсан юм. Түүн дотор энэ асуудал нь явж байсан байх. Харин ТУЗ нь компанийг өөрчлөн байгуулахгүй гээд дэмжээгүй байдаг.

Л.Энхнасан: Намайг Тахько (ХК) компанийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байх хугацаанд Татекс (ХХ) компаниас тайлан баланс өгч байгаагүй.

Б.Батхуяг: Тэр 272,775 ширхэг хувьцаа чинь хэн гэдэг хүмүүсийн нэр дээр байсан бэ?

Ж.Чимэдцэрэн: Ш.Мөнх-Очир, Ц.Наст, Т.Доржготов нарын нэр дээр бүртгэлтэй.

Л.Буянбат: Тэр хүмүүсийн хувьцаа 272,775 ширхэг хувьцаанд хүрэх юм уу? Тэр хүмүүс чинь 80,000 ширхэг хувьцаа тус тус эзэмшдэг биш юм уу.

Ж.Чимэдцэрэн: Тухайн үед компани тусгаарлах гэрээнд хоёр нь 87,000 ширхэг хувьцаатай нэг нь 98,606 ширхэг хувьцаа нь нийлээд 272,775 ширхэг хувьцаа эзэмшиж байсан гэж хаана ч бүртгэлгүй

Ж.Банзрагч: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. За би нэг асуулт асууя. Энэ Татекс (ХХ) компани нь Тахько (ХК) компанийн охин компани мөн үү. ТУЗ-ийн даргаас асууя.

Л.Буянбат: Энэ компани нь 1995 онд хамтарсан компани хэлбэрээр байгуулагдаж бүх хөрөнгө нь Тахько (ХК) компанийн балансаас хасагдсан. Тэр яриад байгаа 80,000 ширхэг хувьцаа нь болохоор 1996 онд гарсан юм.

Ж.Банзрагч: Үлдсэн нь хаана байна.

Л.Буянбат: Үлдсэн 49,596 нь компанийн сангийн хувьцаа хэлбэрээр бүртгэлтэй явж байгаа.

Ж.Банзрагч: Тухайн хөрөнгийн бүртгэлүүд хаана бүртгэлтэй байгаа вэ? Хүмүүсийн ярьж байгаа зүйлүүдийг сонсоод байж байхад энд бантан хутгасан байна. Энэ зүйлүүдийг өөрчлөн Монгол улсын холбогдох хуульд нийцүүлэх хэрэгтэй. Хувьцаанд ноогдох ноогдол ашгаа аваад явж байна уу?

Л.Буянбат: Тухайн хөрөнгө нь Татекс (ХХ) компани дээрээ бүртгэлтэй байдаг. Тэр Ш.Мөнх-Очир гуайн нэр дээр бүртгэлтэй байсан 98,606 ширхэг хувьцааны тал нь буюу 49,303 ширхэг хувьцаа нь Ж.Чимэдцэрэнгийн нэр дээр бүртгэлтэй байгаа. Мөн 40,000 ширхэг хувьцаа нь миний нэр дээр бүртгэлтэй. Үлдэгдэл нь Тахьпрогресс (ХХ) компани дээр, 11,519 ширхэг хувьцаа нь Ш.Мөнх-Очир гуайн нэр дээр байдаг.

Ж.Банзрагч: Өнөөдрийн хурлаар 272,775 ширхэг хувьцааг хасах эсэх тухай ярилцах юм байна гэж ойлголоо. Зөв үү.

Б.Батхуяг: Тийм. Энэ асуудлаар л өнөөдөр хуралдаж байна.

Чимэддорж: Би нэг зүйл тодруулж асууя. Хувьцааг нь хасъя гээд байна уу?

Ж.Чимэдцэрэн: Тийм. Энэ хувьцааг хасъя гэсэн асуудал яригдаж байна.

Алтансүх: Одоо ингээд хасчихлаа гэж бодоё өнгөрсөн хугацаанд авч байсан ногдол ашгийг нөхөн төлүүлнэ биз дээ.

Б.Батхуяг: Наадах чинь энэ асуудал шийдэгдсэний дараагийн явцын асуудал юм. За одоо хурлын дэгийн дагуу асуулт хариултаа зогсооё. Хурлын дотоод дэгийн дагуу хурлын хугацаа хэтэрсэн байна. Саналтай хүн байвал саналаа хэлнэ үү.

Ж.Чимэдцэрэн: Өөр санал хүсэлт асуулттай хүн байгаа юм уу. Хурлын цагийг сунгая. Дундуур нь өөр асуудал ярилцсаар байгаад хугацаа алдчихлаа. Зарим нь ойлголт дутуу үлдэж байх шиг байна.

Б.Батхуяг: Хурлын асуулт хариултын хугацааг сунгах эсэхээр санал хураая. Хурлын асуулт хариултын хугацааг сунгах эсэх асуудлаар 100 хувийн саналаар зөвшөөрч хугацааг сунгахаар боллоо.

С.Дамдиндоо: Би нэг зүйлийг ТУЗ-ийн дарга Л.Буянбатаас асууя. Компанийн тухай хууль дээр хувьцаат компанийн хөрөнгийг дураараа хасаж болдог юм уу. Тэр үед Ж.Чимэдцэрэн та өөр бас байсан юм байна шүү дээ. Танаас асууя. Хоёр газар ногдол ашиг аваад байгаа нь гэмт хэргийн хэлбэртэй болоод байгаа юм биш үү. 1995 онд балансаас хасчихсан гэж байна, тэгж болж байгаа юмуу тэр хассан шийдвэр тогтоол нь хаана байна.

Ж.Чимэдцэрэн: Хоёр хамтарсан компани байгуулж хөрөнгө оруулалт хийсэн учраас охин компани болсон байдаг. Би энэ асуудлыг залруулах гэж олон жил явж байна тэгээд одоо энэ хурлыг хуралдуулах шаардлага гаргасан. Шүүхийн шийдвэрээр өнгөрсөн жил би Ш.Мөнх-Очирын нэр дээр байсан хувьцааны 50 хувь буюу 49,500 ширхэг хувьцааг авсан.

Б.Батхуяг: Хурлын дэгийн дагуу асуулт хариултаа дуусгая.

Ж.Чимэдцэрэн: Одоо бүгдээрээ саналаа хэлье. Тэгээд саналаа бичгээр өгье.

Б.Батхуяг: Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор гишүүд саналаа хэлье.

Ж.Чимэдцэрэн: Би компанийн хувьцаа эзэмшигчийн хувьд одоо саналаа хэлье. Энэ асуудал нь хууль бус гэж үзээд хасуулах хүсэлтэй байгаа бөгөөд энэ асуудлын талаар нухацтай сайн бодоочээ гэж хэлмээр байна. Тэгэхгүй бол энэ хууль бус зүйл нь цаашид үргэлжлээд л байна. Тиймээс бүгдээрээ сайн бодоод хасъя гэсэн саналтай байна.

Г.Ганзул: Санхүүгийн зохицуулах хорооноос зохих шалгалтыг хийгээд энийг хас гээд дүгнэлт нь гарсан байна. Тиймээс хасъя гэсэн саналтай байна.

С.Дамдиндоо: Одоо бүгдээрээ олон жил шүүхээр явж хэрэлдлээ шүү дээ. Бараг 10-20 жил боллоо. Зарим хувьцаа эзэмшигчдийн нас ч хүрэхгүй байна. Тиймээс хэдүүлээ эсрэг талаас нь биш эерэг зөв талаас нь дүгнэлт хийгээд эвтэй сайхан шийдэх саналтай байна.

Ж.Банзрагч: Бид нар хуулийн дор амьдарч аж төрх ёстой учраас хууль зүйд яаж байх ёстой байдаг түүнийх нь дагуу л шийдье гэсэн саналтай байна. Мөн би хувьцаа эзэмшигч С.Дамдиндоогийн хэлсэн саналтай санал нэг байна.

Г.Оюунгэрэл: Энэ асуудал нь зөндөө олон жил үргэлжилсэн процесс байна. Миний гол хэлэх гээд байгаа зүйл нь жижиг хувьцаа эзэмшигчид нь хохирч байна. Эдгээр хүмүүс нь хөрөнгө аваад гарчихсан мөртлөө 22 хувийн санал аваад байдаг. Энэ 272,775 ширхэг хувьцаа нь хасагдсанаар жижиг хувьцаа эзэмшигчдийн хувь өснө, ногдол ашгийн хэмжээ нэмэгдэнэ. Том хувьцаа эзэмшигчид энэ асуудал нь зөвхөн бид нарын асуудал гэсэн талаас харахгүйгээр бас жижиг хувьцаа эзэмшигчдээ бодоочээ гэж хэлмээр байна.

Б.Батхуяг: Өөр санал хэлэх хүн байхгүй бол хурлын дэгийн дагуу санал асуултаа дуусгаад саналаа хураая. Санал хураах асуудал дээр хугацаа заагаагүй байгаа.

Тооллогын комисс санал хураалтыг эхлүүлж саналын хуудсыг бөглүүлэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэв.

Тооллогын комиссын дарга Д.Минжмаа Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирцийн тухай тооллогын комиссын 01, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцсэн асуудлаар хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг тоолж, тооллогын дүнг нэгтгэн дүнгийн тухай 02 дугаар тогтоолыг тус тус бүрэн эхээр нь уншиж танилцуулав. (Тооллогын комиссын 2015 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 01, 02 дугаар тогтоолыг хавсаргав)

Б.Батхуяг: Өнөөдрийн ээлжит бус хуралд оролцож байгаа саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс өгсөн саналыг тоолсон Тооллогын комиссын шийдвэрийн дүнгээр компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд саналын эрх бүхий 1,189,983 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчид оролцохоос 1,052,292 ширхэг саналын эрх бүхий энгийн хувьцаа эзэмшигчид оролцож, 641,268 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу нийт саналын эрхийн 60.94 хувийн эзэмшигчдийн саналаар татгалзаж, зөвшөөрөөгүй байна.

Иймд компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар өгсөн саналын эрхийг тоолсон Тооллогын комиссын дүнгээр Тахько (ХК) компанийн үнэт цаасны бүртгэлийг хэвээр үлдээж, тухайн хурлаас гарсан шийдвэр тогтоолыг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн олонхийн саналаар батлагдсаныг мэдэгдэж, тогтоолын төслийг уншиж танилцуулав. (Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит бус хурлын 01 дүгээр тогтоолыг хавсаргав).

Хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул хурлыг 12:38 цагт хаав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ
ХӨТӨЛСӨН:

ТАНИЛЦСАН:
ХУРЛЫН ДАРГА



Э.ЧУЛУУНТОГТОХ

Б.БАТХУЯГ

